

Хууль зүйт сайн 2016 оны
А-204 дүгээр тушаалаар батлан



МОНГОЛ УЛС ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000102381

2020.01.09

/Бүртгэсэн өн сурталбар /

0114001014

/Хэрэглэх өрхний дугаар /

3012391

/Регистрийн дугаар /

Чулуут ахуй үйлчилгээний ТОО

/Хуулийн этгээдийн нэр, хэрэглэх өрхний дугаар /

Дэвсгэрийн төрөлтэй үйлдвэрийн
гэзэр

Дүрэм

/Үүсгэн байгуулсан баримт бичиг /

Шийдвэр

/Шийдвэрийн нэр /

01

/Дүрэм /

2019.04.18

/Огноо /

82090

/Код /

Бизнесийн үйл ажиллагаа

/Үйл ажиллагааны нэр /

Хүтээнэгүй

/Хүтээнэгүй /

1

/Хүтээнэгүй /

0,00

/Хөрөнгийн гэрээг, мөнгөн тэнгэр /

Архангай, Чулуут 2-р бол, Зуунмод 0, Утас1: 89086800, Утас2: 89910581, Факс:

/Хуулийн этгээдийн ахуйн өрхний нэр /



Улсын бүртгэлийн ерөнхий газар
Архангай аймгийн улсын бүртгэлийн
хэлтэс

/Бүртгэсэн байгууллагын нэр /



АРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 32

Эрдэнэбулган сум

“Чулуут-Ахуй үйлчилгээний төв”
Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой
үйлдвэрийн газар байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 ж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Чулуут- Ахуй үйлчилгээний төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгуулж, дүрмийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ӨСӨХБАЯР



“ЧУЛУУТ-АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь “Чулуут-ахуй үйлчилгээний төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт, эрх бүхий албан тушаалтан, үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах харилцааг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэхэд оршино.

1.2. “Чулуут-ахуй үйлчилгээний төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь /цаашид “үйлдвэрийн газар” гэх/ сумын иргэдийг үйлдвэрлэл эрхлэх нөхцөл боломжоор хангах, үйлдвэрлэж, бий болгосон бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлж, ажлын байраар хангах чиг үүрэг бүхий орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар мөн.

1.3. Үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид байна.

1.4. Үйлдвэрийн газар нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан тогтоол, шийдвэр, энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

Хоёр. Үйлдвэрийн газрын оноосон нэр, оршин байгаа газар

2.1. Үйлдвэрийн газрын оноосон бүтэн нэр нь “Чулуут-ахуй үйлчилгээний төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, товчилсон нэр нь “Чулуут-ахуй үйлчилгээний төв” ОНӨААТҮГ байна.

2.2. Үйлдвэрийн газрын оршин байгаа газар нь: Монгол улс, Архангай аймаг, Чулуут сум, 2 дугаар баг, “Чулуут-ахуй үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын өөрийн байр.

Гурав. Үйлдвэрийн газрын бэлгэдэл тэмдэг

3.1. Үйлдвэрийн газар нь өөрийн бэлгэдэлтэй байж болох бөгөөд албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

3.2. Бэлгэдлийн загварыг захирал баталж, оюуны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлсэн байх бөгөөд түүний хэрэглэх эрхийг зөвхөн үйлдвэрийн газар эдэлнэ.

3.3. Тэмдгээр үйлдвэрийн албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

3.4. Тэмдгийг үйлдвэрийн газрын захирал эсхүл итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцна.

Дөрөв. Үйлдвэрийн газрын үндсэн зорилт, үйл ажиллагааны чиглэл

4.1. Үйлдвэрийн газрын үндсэн зорилт нь сумын иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг хямд үнээр худалдан борлуулахад, ажлын байраар хангахад оршино.

4.2. Үйлдвэрийн газар нь хууль тогтоомжоор хориглоогүй бусад бизнесийн үйл ажиллагааг эрхэлж болно.

4.3 Үйлдвэрийн газар нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

4.4. Үйлдвэрийн дүрэм нь хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

Тав. Үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүрэг

5.1. Үйлдвэрийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан эд хөрөнгийн эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

5.2. Үйлдвэрийн газар нь өөрийн эзэмшиж буй эд хөрөнгийн хэмжээгээр эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

5.3. Үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй байна.

5.3.1.Өөрийн балансад бүртгэлтэй хөрөнгийг хууль дүрэмд заасан үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах эрхтэй.

5.3.2 Үйлдвэрийн газрын цэвэр ашгаас өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгууллагын үндсэн зорилтод нийцсэн төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулалтыг зохих журмын дагуу хийх эрхтэй.

5.3.3 Үйлдвэрийн газар нь Орон нутгийн өмчийн газрын шийдвэрийг үндэслэн үндсэн хөрөнгө олж авах, акталж данснаас хасах, худалдан борлуулах, устгах, шилжүүлэх эрхтэй.

5.3.4 Үйлдвэрийн газрын барилга байгууламж, эд хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3 дах хэсгийг баримтлан ажиллана.

Зургаа. Үйлдвэрийн газрын удирдлага

6.1. Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдана.

6.2. Захирлыг аймгийн Засаг даргатай зөвшилцөн сумын Засаг дарга хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнө.

6.3. Захирал нь сумын даргатай гэрээ байгуулан ажиллах бөгөөд биелэлтийг бүрэн хариуцна.

6.4. Үйлдвэрийн газрын захирлыг орлох албан тушаалтныг "Хөдөлмөрийн дотоод журам"-д заасан байна.

6.5. Үйлдвэрийн газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг сумын Засаг дарга батална.

6.6. Орон нутгийн өмчийн газар нь үйлдвэрийн газрыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

6.7. Захирал нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна.

6.7.1. Үйлдвэрийн газрын итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй.

6.7.2. Монгол улсын хууль, тогтоомжид нийцүүлэн тушаал, шийдвэр гаргах эрхтэй.

6.7.3. Үйлдвэрийн газрын байрыг эрх бүхий байгууллагаас тогтоосон үнээр түрээслэх гэрээ байгуулах, цуцлах, сунгах, түүнчлэн өөрийн ашиг орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах эрхтэй.

6.7.4. Үйлдвэрийн газрын хөрөнгийг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу эзэмших, ашиглах эрхтэй.

6.7.5 Үйлдвэрийн газрын ажилтныг ажилд авах, чөлөөлөх, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй.

3/

6.7.6. Эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн сангийн хэмжээнд багтаан цалин тогтоох, өөрчлөх, урамшуулал олгох, ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлэх эрхтэй.

6.7.7 Үйлдвэрийн газрын ажилтнуудын дагаж мөрдөх журам батлах эрхтэй.

6.7.8 Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй.

6.7.9 Үйлдвэрийн газрын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулж биелэлтийг хангуулах үүрэгтэй.

6.7.10. Хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

6.8 Үйлдвэрийн газрын захирал, нягтлан бодогчийн албан тушаал эрхэлдэг этгээдийг эрх бүхий албан тушаалтанд тооцно.

Долоо. Үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих

7.1. Үйлдвэрийн газар нь санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байх бөгөөд дотоод хяналт тавих журмыг захирал батална.

7.2. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын байгууллагаар шалгалт хийлгүүлнэ.

7.3. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтад Орон нутгийн өмчийн газар хяналт тавьж ажиллана.

7.4. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ.

Найм. Үйлдвэрийн газрын санхүү, бүртгэл

8.1. Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргана.

8.2. Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал, нягтлан бодогч нар хариуцна.

8.3. Үйлдвэрийн газрын нягтлан бодогч нь мэргэжлийн байх бөгөөд түүнийг Санхүү, төрийн сангийн хэлтэстэй зөвшилцсөний дагуу захирал томилж, чөлөөлнө.

8.4. Үйлдвэрийн газрын санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12-р дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

Ес. Үйлдвэрийн газрын санхүүжилт, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

9.1. Үйлдвэрийн газрын орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ:

9.1.1. Түрээсийн үйлчилгээнээс олсон орлого;

9.1.2. Байгууллагатай хамтарч ажиллах гэрээний дагуу олсон үйлчилгээний орлого.

9.1.4. Хандивлагч орнуудын зээл, тусламж болон буцалтгүй тусламж;

9.1.5. Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр;

9.2. Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

9.2.1. Баланс

9.2.2. Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан

9.2.3. Мөнгөн гүйлгээний тайлан

9.2.4. Өмчийн өөрчлөлтийн тайлан

9.2.5. Нэмэлт тайлбар;

9.2.6. Санхүүгийн тайлангийн тодруулга;

9.2.7. Бусад;

9.3 Үйлдвэрийн газар үйл ажиллагааныхаа тайланг Санхүү, төрийн сангийн хэлтэст, тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, зөрцуулсан хөрөнгө санхүү, үр дүнгийн тайланг Орон нутгийн өмчийн газарт хүргүүлднэ.

9.4 Үйл ажиллагааны тайланд доорх зүйлийг тусгасан байна:

9.4.1 Тайлангийн хугацаанд үйлдвэрийн газрын эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлт болон эдгээрийн үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт.

9.4.2 Тайлангийн хугацаанд үйлдвэрийн газрын албан тушаалтан, ажиллагсдад олгосон шагнал урамшуулал, удирдлагын зардлын хэмжээ.

9.4.3 шаардлагатай бусад мэдээлэл, тайлбар.

Арав. Үйлдвэрийн газрын бичиг баримтыг хадгалах

10.1. Үйлдвэрийн газар нь дараах бичиг баримтыг хадгална.

10.1.1. Үйлдвэрийн газрын дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга, үүсгэн байгуулах эрх бүхий байгууллагын шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээболон эрх лиценз, тусгай зөвшөөрөл сертификат.

10.1.2. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн аудитын дүгнэлт, зөвлөмж.

10.1.3. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримтууд;

10.1.4. Үйлдвэрийн газрын стандарт, норм нормативууд түүнтэй холбогдох дүрэм, журам, зааврууд, бусад бичиг баримт.

10.1.5. Хурлын тэмдэглэл, шийдвэр, захирлын гаргасан тушаал, шийдвэрүүд;

10.1.6. Бусад ач холбогдол бүхий баримт бичгүүд;

10.2. Дээрх бичиг баримтыг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах архивт шилжүүлэх зэрэг ажлыг холбогдох албан тушаалтан эрхлэн гүйцэтгэнэ.

Арван нэг. Үйлдвэрийн газрыг татан буулгах, өөрчлөх

11.1. Үйлдвэрийн газрыг Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан үндэслэл, журмыг баримтлан эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буулгах эсхүл өөрчлөн зохион байгуулна.

Арван хоёр. Бусад

12.1. Энэхүү дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

12.2. Үйлдвэрийн газрын энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

12.3. Үйлдвэрийн газрын дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

* * * * *

БАТГАЕ ЧУЛУУТ СУМЫН АДАГ ДАРГА

Handwritten mark

“ЧУЛУУТ АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ” ОНӨААТҮТ-ийн 2022 ОНИН ЗАРДЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үзүүлэлт	Сар	Жилийн нийт зөрдөл	Эзлэх хувь
1	Ажиллагаанд нэвтрэн Үндсэн ба нэмэгдэл	12	6	
2	цалин (НДШ, ХАОАТ)	12	34081500	72.9
3	Гэрэл цахилгаан	12	9360000	14.4
4	Тулш хөдөөт	12	5600000	7.8
5	Цэвэр хайргал	12	3000000	2
6	Хол хайргал	12	1000000	0.2
7	Бусад төлбөр хувиар	12	800000	0.7
8	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		51665500	100
9	НИЙТ ОРЛОГЫН ДҮН		5200000	
10	АШИГ АЛДАГДАЛ		36500	



Handwritten signature

ЗАХИРАЛЧ, МЭДЭЛЭЛЭГ

Handwritten signature

Улаанбаатар